

Батлав. Монгол Улсын Ерөнхий Сайд, Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогын улсын комиссын дарга У.Хүрэлсүх



УХА0449

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

- 1.1 Тооллогын улсын комиссын үйл ажиллагааны зорилго нь хүн ам, орон сууцны ээлжит тооллогын ажлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, тооллогын бэлтгэл ажлыг хангуулах, үр дүнг нэгтгэн гаргахад нэгдсэн хяналт тавьж, чиглүүлэх, тооллогод тодорхой үүрэгтэйгээр оролцох яам, агентлагуудын ажлын уялдаа холбоо, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангахад оршино.
- 1.2 Тооллогын улсын комисс нь Монгол Улсын "Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай" хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан энэхүү журмыг удирдлага болгон мөрдөн ажиллана.

2. Тооллогын улсын комиссын эрхлэх ажлын хүрээ, үйл ажиллагааны зохион байгуулалт

- 2.1. Тооллогын улсын комисс нь "Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай" Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 5-д заасан бүрэн эрхтэй байна.
- 2.2. Тооллогын улсын комисс нь жил, улирлын төлөвлөгөөтэй ажиллана.
- 2.3. Тооллогын улсын комисс нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана.
- 2.4. Хурлаар Монгол Улсын "Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 5.2-т заасан комиссуудын дарга нарын сонсголыг авч хэлэлцэх, ажлын явцыг газар дээр нь шалгах, удирдамж чиглэлээр хангах, комиссуудын ажлыг хооронд нь уялдуулах арга хэмжээ авна. Тооллогын бэлтгэл ажлын явцын талаар ҮСХ-ны даргын сонсголыг улирал тутам хэлэлцэж, дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- 2.5. Монгол Улсад оршин сууж буй гадаадын иргэдийг тооллогод хамруулах талаар элчин сайдын яамнуудтай ГХЯ-аар дамжуулан хамтран ажиллах ажлыг зохион байгуулна.

- 2.6. Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд өрх, иргэний бичиг баримтын зөрчлийг арилгуулах, тооллогын нэгж болох өрх, хүн амын бүртгэлийг батлагдсан маягтаар гаргах, засаг захиргаа завсардсан, тухайн орон нутаг дэвсгэртээ оршин суух бүртгэлгүй иргэдийн асуудлыг тооллого явагдахаас өмнө бүрэн цэгцэлсэн байх үүргийг бүх шатны засаг дарга нарт өгч, хэрэгжилтийг хангуулна.
- 2.7. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, холбогдох яамдын тооллогын комиссын дарга нарын сургалтыг ҮСХ-той хамтран зохион байгуулна.
- 2.8. Тооллогын тусгайлсан комисс байгуулагдаагүй яам, агентлагуудын тооллоготой холбоотой асуудлыг уялдуулан зохицуулна.
- 2.9. Тооллогод шаардагдах хөрөнгө санхүүгийн асуудлыг хэлэлцэж, төсөвт тусгах болон гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх саналыг боловсруулж шийдвэрлэнэ.
- 2.10. Тооллогын улсын комисс нь аймаг, нийслэл, дүүргийн тооллогын комиссын бүрэлдэхүүнд зайлшгүй орох албан тушаалтан, гишүүдийн тоо, ажиллах зарчмыг тогтооно.
- 2.11. Тооллогын ажилд түр хугацаагаар ажиллагчдын цалин, хөлс бусад асуудлыг зохицуулж шийдвэрлэнэ.
- 2.12. Тооллогын улсын комисс нь хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргана.
- 2.13. Тооллогын улсын комисс нь тамга, албан хэргийн бланктай байна.

3. Тооллогын комиссын гишүүний чиг үүрэг

- 3.1. ҮСХ нь Монгол Улсын "Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 6-д заасны дагуу тооллогын улсын комиссын ажилд арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.
- 3.2. Комиссын гишүүд нь өөрсдийн хариуцах ажлын хүрээнд хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх бүх талын арга хэмжээг авч, явцыг Комиссын хуралд тайлагнадаг байна.
- 3.3. Комиссын хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, өөрийн үнэлэлт дүгнэлтээ бичгээр ирүүлж, хурлаас гарах шийдвэрт тусгуулдаг байна.
- 3.4. Комиссын гишүүд нь энэхүү журам, комиссын шийдвэрээр өгсөн үүргийг нарийн чанд мөрдөж хэрэгжүүлнэ.

4. Тооллогын комиссын хурлаар хэлэлцэх асуудал

- 4.1. Комиссын ажиллах журам, гишүүдийн ажлын төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах.
- 4.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, холбогдох яамдын тооллогын комиссын дарга нарын сонголыг авч хэлэлцэж, тулгамдаж байгаа асуудлаар шийдвэр гаргах.
- 4.3. Комиссын ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийн явцыг хэлэлцэх.

- 4.4. ҮСХ-ноос боловсруулсан хүн ам, орон сууцны тооллогын асуулга, зааврыг хэлэлцэж санал өгнө.
- 4.5. Хүн ам, орон сууцны туршилтын болон ээлжит тооллого, хяналтын тооллого явуулах ажлын зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэнэ.

5. Хурлын дэг

- 5.1. Комиссын хурлыг дарга, түүний эзгүйд орлогч дарга удирдан явуулна.
- 5.2. Хурлыг комиссын гишүүдийн 75-аас доошгүй хувийн ирцтэй үед хуралдуулах бөгөөд улирал тутам хийж байна.
- 5.3. Асуудлыг хуралд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 5.4. Комисс нь төлөвлөгөөтэй ажиллаж, хурлыг хуваарийн дагуу хийнэ.

6. Хурлын шийдвэр

- 6.1. Хурлаар хэлэлцсэн асуудлаар гарсан санал, дүгнэлт шийдвэрийг протокол үйлдэж, шаардлагатай асуудлаар тогтоол гаргаж баталгаажуулна.
- 6.2. Комисс нь ажлаа хагас жил тутам УИХ-д тайлагнана.

--- о О о ---